

**ТАВАНТОЛГОЙ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2015 ОНЫ ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2015-04-24

Тавантолгой

Хурал 2015 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Тавантолгой ХК-ийн хурлын зааланд 15:10 цагаас эхлэн хуралдас.

Хуралд оролцсон :

- Б.Түвшинбаяр
- Д.Дагавадорж
- Д.Ганболд
- Ч.Жаргалсайхан
- А.Жаргалсайхан

Тавантолгой ХК-иас:

P.Сэддорж	- Гүйцэтгэх захирал
Г.Шүрэнхишиг	- Нягтлан бодогч
Ч.Төрмандах	- Эдийн засагч
Т.Жамбал	- Эдийн засагч
Б.Цэрэнпагма	- Хангамжийн ажилтан
В.Сайнбилэг	- Нарийн бичиг

Хурлын ирц 97 %-тай байлаа

Хурлын Тооллогын комиссын дарга Б.Цэрэнпагма хурлын ирцийг танилцууллаа 97.3 %-ийн ирцтэй байлаа.

Хурлын дарга Б.Түвшинбаяр хурлыг нээснийг мэдэгдэж үг хэлж Хурлын дэгийг танилцууллаа.

**Б.Түвшинбаяр** – хурлын дэгийг танилцуулья Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 14 цагт компанийн хурлын танхимд гэсэн байна одоо 15 цаг 10 мин болж байна.

1. Ирц гаргах, хурлын даргад мэдээлэх /Тооллогын комиссын дарга/
2. Хурлыг нээх, хурлын тэргүүлэгчдийг сонгох /Хурлын дарга/
3. Хурлаар хэлэлцэх асуудал болон хурлын дэг батлах / Хурлын дарга /

4. Компанийн 2014 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан /Гүйцэтгэх захирал/
5. Компанийн 2014 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт /ТУЗ-ийн дарга/
6. 2013 оны ногдол ашиг хуваарилалтын тайлан, 2014 оны ногдол ашиг хуваарилалтын тухай /Нягтлан/
7. ТУЗ-ийн 2015 оны төслийн тухай /Нягтлан/
8. Асуулт /1мин/
9. Хариулт /3 мин/
10. Санал, шүүмжлэл /5 мин/
11. Завсарлага /2 цаг тутамд/
12. Санал хураалт явуулах /Тооллогын комисс/
13. Тооллогын комиссын тогтоол танилцуулах /Хурлын дарга/
14. Хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулах, батлах /Хурлын дарга/
15. Хурлыг 4 цагт багтаан явуулах

**Б.Түвшинбаяр –**Хурлын дэг-нд санал байна уу ? хурлын дэгээ батлах уу гараа өргөн үү?

**Хувьцаа эзэмшигчдийн 100 %-ийн саналаар хурлын дэгийг батлав.**

**Б.Түвшинбаяр-** Хурлын хэлэлцэх асуудлыг танилцуулья Уүнд:

Компанийн 2014 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан /Р.Сэддорж/

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар/ТУЗ-ийн дарга/
2. 2013 оны ногдол ашиг хуваарилалтын тайлан, 2014 оны ногдол ашиг хуваарилалтын тухай
3. ТУЗ-ийн 2015 оны төсвийн тухай

**Б.Түвшинбаяр –**Хэлэлцэх асуудалд санал байна уу ? хэлэлцэх асуудлаа батлах уу гараа өргөн үү?

**Хурлын хэлэлцэх асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн 100 %-ийн саналаар батлав.**

Компанийн 2014 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан Гүйцэтгэх захирал Р.Сэддорж:

- Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, хөрөнгийн эзэд та бүхний энэ өдрийн мэндийг эрэн мэндчилж байна.
- 2014 онд ТЭЗҮ, УАТөлөвлөгөө, Орон нутгаас өгсөн ерөнхий чиглэлийн дагуу 2 сая тонн нүүрс олборлон борлуулах төлөвлөгөөтэй ажиллаа.
- 645,5 мян.тн нүүрс олборлон 554,5 мян.тн нүүрсийг экспортод, 91 мян.тн нүүрс дотоод зах зээлд нийлүүлэн нүүрсний төлөвлөгөөний биелэлт 32,2 хувьтай байлаа.

- Коксын үйлдвэрийг сэргээж 233 тн кокс боловсруулж дотоодын зах зээлд борлуулж ажиллаа. Дотоодод борлуулсан нүүрсний 6285,65 тн-ийг Өмнөговь аймгийн төвийн нүүрс борлуулах цэгээр борлуулсан ба 21044,1 тн нүүрсийг 10%-ийн хямралтайгаар хэрэглэгчдэд борлуулсан.
- 2014 онд нийт 30,8 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдэн 24,7 тэрбум төгрөгийн зардал гаргаж 3,6 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллаа.
- Улс болон орон нутгийн төсөвт нийт 10,2 тэрбум төгрөгийн татвар хураамж төвлөрүүлсэн байна. Үүнээс:
  1. ААНОАТатвараар 5,2 тэрбум төгрөг
  2. АМНАТөлбөрөөр 4,3 тэрбум төгрөг
  3. НӨАТатвараар 1,4 тэрбум төгрөг
  4. Агаар бохирдлын Татвараар 514,3 сая төгрөг
  5. ХАОТатвараар 546,4 сая төгрөг эзэлж байна.
- 2013 оны ногдол ашгийн 40,3 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд олгож байна.
- 2014 онд 177 хүний бүрэлдэхүүнтэйгээр 5-н Албадын зохион байгуултайгаар ажиллаж, Гүйцэтгэх захирлын ажлын хүрээнд нийт 291 тушаал шийдвэр гарган 19 ажилтан шинээр авч 16 ажилтан хууль тогтоомжид заасан заалтын дагуу өндөр насны тэтгэвэрт гарах болон өөрийн хүсэлтээр болон тодорхой зөрчлийн улмаас ажлаас чөлөөлөгдсөн байна. Тэтгэвэрт гарсан 4 ажилтанд дотоод журамд заасны дагуу 30сая төгрөгийн тусламж үзүүлсэн. Туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн хүрээнд 450 орчим ажилтныг ажлын байраар хангаж ажилласан.
- Оюутны тэтгэлэгт хөтөлбөрт компанийн алба хаагчдын 12 хүүхэд хамрагдаж 10 хүүхэд нь төрийн албан хаагчийн хэмжээгээр, 2 оюутан нь 100%-н тэтгэлэгт хамрагдсан.
- Компанийн нээлттэй өдөрлөгийг Баяндалай, Цогт-Овоо, Цогцэций, Манлай, Ханбогд, Баян-Овоо сумдад зохион байгуулж сум тус бүрийн уугуул иргэдийг татан оролцуулах, нөхөрсөг тэмцээн уралдаан зохион байгуулах, сурагч хүүхдүүдийн дунд уран илтгэл, зохион бичлэгийн уралдаанууд явуулан өргөн цар хүрээг хамран үр дун өндөртэй арга хэмжээ болсон.
- Бизнес төлөвлөгөөнд тусгаснаар 2014 оны цалингийн сан 1,238,56 тэрбум төгрөг байсан бол гүйцэтгэлээр 1,160,56 тэрбум төгрөг болж 78,0 сая төгрөг хэмнэсэн. ТУЗ-ийн цалин 141,2 сая төгрөг ТУЗ-ийн үйл ажиллагааны зардал 368,9 сая төгрөг байсан бол гүйцэтгэлээр 180,0 сая төгрөг болж 48.9 хувиар хэмнэсэн.

- 2015 онд удирдлагын зүгээс нүүрс борлуулалт, ачаа тээвэрлэлт, гүний гаалийн асуудлуудыг шийдвэрлэх, цаашлаад нүүрсийг ангилан ялгах, баяжуулах, нүүрсний шинэ технологи нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.
- 2015 онд хийж бүтээхийн өрнүүн сэтгэлээр дүүрэн байж та бүхний ажилд сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Баярлалаа.

**Компанийн 2014 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт: Б.Түвшинбаяр**

- Сүүлийн 5 жилд төлсөн татвараараа улсдаа 5-р орсонд ТУЗ болон нийт Х.Э-ын өмнөөс талархал илэрхийлье
- 2014 онд 4,7 сая м3 хөрс хуулж, 645,5 мян.тн нүүрс олборлож, 233 тн кокс боловсруулж, нийт 30,8 тэрбум төгрөгийн борлуулалт хийж төлөвлөгөөг 32,2 хувьтай тус тус биелүүлсэн байна.
- 2014 оны жилийн эцсээр 3,6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.
- 2014 онд Гүйцэтгэх захиралд тодорхой чиг хандлага өгч зайлшгүй шаардлагатай асуудлуудыг шийдэж ирлээ
- Байгаль орчны тал дээр анхаарч шороон замаар тээвэрлэлт хийхийг зогсоож авто замаар тээвэр явуулахыг бүхий л хичээл зүтгэлээ дайчлан нүүрс тээвэрлэх авто замын төлбөрийг буулгаж чадсан.
- Гашуун Сухайт авто зам, Гашуун Сухайт төмөр зам компаниудын хувьцааг эзэмшиж ажиллаж байна
- Олон жил шүүхийн маргаантай байсан голын газар буюу 100 мяанган га газрыг бүх шатны шүүхийн өмгөөлөл хийж ялалт байгуулж уурхайн тусгай зөвшөөрлийн талбай 276,9 га хүрч талбайд оногдох нүүрсний хэмжээг уул уурхайн эрдэс баялгийн зөвлөлөөр батлуулсан байна.
- ТУЗ-өөс өгсөн чиг үүргийн дагуу Өмнөговь аймгийн төвийн нүүрс борлуулах цэгээр өвөлжилтийн бэлтгэл ажилд нүүрсийг 1 сарын хугацаатайгаар хямдруулан борлуулсан байна.
- Анхаарал тавьсанд баярлалаа

**2013 оны ногдол ашиг хуваарилалтын тайлан, 2014 оны ногдол ашиг хуваарилалтын тухай Ерөнхий нягтлан Г.Шүрэнхишиг:**

- Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчдээ

- ТТ ХК нь 2013 онд 62,1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж 2014 оны Х.Э.Х-аар нэгж хувьцаанд 766 төгрөг ба 40,3 тэрбум олгохоор зарласан.
- Х.Э.Х-д өөрийн биеэр болон материалаа бүрдүүлж өгсөн Х.Э –дэд 7,8 тэрбум төгрөг олгосон.
- 2014 онд 32,6 тэрбум төгрөгийн орлоготой, 28,4 тэрбум төгрөгийн зардалтайгаар ажиллан, 4,2 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж 565,2 төгрөгийг ААНОТатварт төлж 3,6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаа.
- 2009 онд цэвэр ашгийн 90% ба 550 ₮, 2010 онд цэвэр ашгийн 90% ба 1300 ₮, 2011 онд цэвэр ашгийн 90% ба 1368 ₮, 2012 онд цэвэр ашгийн 85% ба 151 ₮, 2013 онд цэвэр ашгийн 65% ба 766 ₮ тус тус олгож байсан ба 2015 оны 1 сард 2013 оны 5% ба 59 төгрөгийн ногдол ашиг нэмж олгохоор зарлаад байна.
- 2014 оны ногдол ашигт та бүхэн саналаа өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТУЗ-ийн 2015 оны төслийн тухай /ТТ ХК-ийн 2014 оны ТУЗ-ын зардлын гүйцэтгэл ба 2015 оны төлөвлөгөө/ Ерөнхий нягтлан Г.Шүрэнхишиг:**

- 2014 оны 4 дүгээр сарын 30-ны Х.Э.Х-аар бид 2013 оны зардлыг 368,9 сая төгрөгөөр баталсан.
- ТУЗ НЬ 2013 онд үйл ажиллагааны зардалд нийт 260 704,5 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 108 247,5 мянган төгрөг ба 29,35 % -иар хэмнэлттэй ажилласан байна.
- Зардлын зүйл бүрээр хэмнэж ажиллаа.
- ТУЗ-ын задралыг 2015 онд 346,7 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж байна
- Та бүхэн ТУЗ-йн задралын төлөвлөгөөг зөвшөөрч байгаа бол хурлаар батална уу?

**Б.Түвшинбаяр:**

Уурхайн ажилчид 60%-ласан байгаа мөн ТУЗ-ын гишүүд 60%-лахаар болсон байгаа.

ТТ ХК маань өнөө жил ТОП аж ахуйн нэгээр шалгарч өргөмжлөлөө хүлээж авсан байгаа баяр хургэе

Хэлэлцэх асуудал дээр бусад асуудал дээр нэмэгдсэн 3 асуудал байгаа

1. 2013 оны Н.А-ийг 87%- иар хэлэлцэх
2. ТУЗ –ын гишүүдийг сонгох
3. Нүүрсний борлуулалтын талаар Х.Э.Х-аас шийдвэр, чиглэл гаргах

1. 2013 оны цэвэр ашгаас нэмэлт ногдол ашиг хувиарлах санал 65 % + 20 % нэмэгдээд нэгж хувьцаа нь 766 болж байгаа нэмэгдэх нь 259,60 болж орон нутагт ногдох ногдол ашиг 6,972,674,280

2014 онд олгосон 766 төгрөгөөр 20,574,233,800 өгсөн байгаа.

2. Орон нутгийг төлөөлж байгаа 51 %-тай талаас 5 хүнээ өөрчлөх санал байхгүй Ажнай талаас санал байхгүй, Ээрмэлээс санал байхгүй хуучин гишүүдийг сонголоо Үүнд:

Хуралд оролцогсдын 13,69%-иар Б.Түшинбаяр, 13,64 %-иар А.Жаргалсайхан, 13,64 %-иар А.Идэрцог, 23,74 %-иар Д.Дагвадорж, 13,64%-иар Ц.Мөнхдэлгэр, 21,64 %-иар С.Мөнхжаргал нарыг ТУЗ-ын энгийн гишүүнээр

Хараат бус гишүүнээр 54,25 %-иар Л.Батчулуун, 23,94 %-иар Д.Ганболд, 21,81 %-иар Т.Тэгшээг тус тус сонголоо.

**Гүйцэтгэх захирлын тайлантай холбоотой асуулт байна уу? Б.Түвшинбаяр:**

**Дамчий:**

Төмөр замын талаар, нүүрсний зах зээл дээр Монголын талаас ямар арга хэмжээ авч байна бүгдийг л БНХАУ-д буруугаа хэлээд байх шиг манай засгийн газар муу ажиллаж байна уу даа

**Р.Сэддорж :** Гашуун Сухайт төмөр зам бол хилээс наашаа гарч ирээд 3 гарц 3 компани гаргаж өгөөд тэгээд хойноос ирэх төмөр замтай холбогдох юм байгаа юм. Монголын талаасаа галт тэргэнд нүүрсээ ачаад тэгээд шууд далайн боомт хүргэх тийм зорилготой байгаа юм.

Монголын засгийн газар бол нүүрсний зах зээлийн уналтын тал дээр арга хэмжээ авч ямар л буулгаж болох боломжууд дээр арга хэмжээ авч ажиллаж байна дэлхийн хамгийн том зах зээлтэй БНХАУ-ын зах зээл унахаар яалтачгүй монгол нөлөөлж байна.

**Л.Нямжав:**

Дэлхийн зах зээл хямралтай эдийн засаг уналттай хэдий ч энэ асуудлаас гаргах арга бол уг компани нь өндөр менежментэй баймаар байна.

Орон нутаг анхаарч нэгдсэн нэг бодлоготой худалдан авагчаа булаахгүй, үнээ унгахгүйгээр ажиллах хэрэгтэй гэж бодож байна.

### **Д.Дагавадорж:**

2005 хойш менежменттэй хамгийн сайн ажиллаж өргүй, ногдол ашгаа хувиарлаад явж байгаа нүүрсний уурхай байхгүй. бид нар хөрш 2 уурхайгаа дагаад яваад байвал адилхан өрөнд орж дампуурна. Өөрийн гэсэн менежменттэй ажиллаж кокс үйлдвэрлэл, боловсруулах угаах үйлдвэр зэрэг олон талын ажил хийх хэрэгтэй байх. Энэ талаар ТУЗ болон Х.Э –ээс зөвшөөрөл гаргуулах хэрэгтэй. Одоо манай компанийтай гэрээтгэй 10 гаруй компани тээвэрлэлт хийж байгаа эдгээр компаниуд өөр өөрийн гэсэн үнээр зарж байгаа энийг болиод гол ажил хийдэг 3 компанийг хийх хэрэгтэй энэ тал дээр Х.Э санал өгөх хэрэгтэй энэ 3 компани хөрсөө хуулах хэрэгтэй одоо уурхайгаа бодох, Х.Э –ээ бодох цаг болсон.

### **Г.Цог-Өрнөх:**

Х.Э-дээ энэ өдрийн мэнд хургэе

Юуны өмнө 2014 онд ашигтай ажиллаж ногдол ашиг ярьж байгаад сайшаалтай хэрэг

Гүйцэтгэх захирлын тайлан Х.Э-тэйгээ саналаа солилцох хэмжээнд, ийм ажил хийж гэж дүгнэж цаашид ямар ажил хий талаар менежменттэй байвал зүгээр байх

Энэ Х.Э.Х-аас том том чиглэлүүдийг авч байх хэрэгтэй байх Угаах үйлдвэр замын харилцаа хэтээ бодох хэрэгтэй хямралын эдийн засгийн менежментийн төлөвлөгөө гаргаж батлуулах ёстой.

### **Д.Ганболд:**

Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа ирсэн бүх хүмүүстээ баярлалаа

Өнгөрсөн 2014 онд эдийн засаг хямралтай байсан боловч заавал төлөх байсан 80 тэрбумын шүүхийн өрөөс салсан, голын газраа авч уурхайн нөөц хангалттай боллоо эдгээр ажлууд дээр сайн ажилласан хүмүүст урамшуулал өгөх хэрэгтэй. Ганц өнөөдрөө хараад ажиллаад байж болохгүй манайх нойтон аргаар нүүрс боловсруулах талаар ярилцаад.govъд зохицохгүй гээд дэмжээгүй байгаа одоо хуурай аргаар нүүрс боловсруулах технологийн талаар ажлууд хийж байгаа танилцуулсан байгаа энэ талаар аймгийн И.Т.Хуралд танилцуулаач гээд Сэддорж захиралд өгсөн байгаа.

### **Б.Хүүхнээ:**

Уурхайд улдээх ёстай юмаа үлдээх л хэрэгтэй энэ уурхайг байлгая гэж бодож байгаа бол дахин дахин хувирлах хэрэггүй юм байгаан.

### **P.Зоригтбаатар:**

Өмнөговийн ард иргэдийг бодож байна гээл хэдий хүртэл тээж аваачиж өгч байгаа бүх машинаа дуусгалаа одоо бол 2000 оноос шал өөр болсон болохоор зах зээлийн нөхцөлөө бодоод болих хэрэгтэй байна.

Зах зээлээ нэмэгдүүлэхийн тулд бүх орон нутагт нэг үнийн түвшин барьж орон нутгийн хэрэглээг нэмэгдүүлэх хэрэгтэй.

Өөр зах зээл рүү орж ажиллах хэрэгтэй зам, хайгуул г,м өөр юу байдгийн усаар болон хуурай аргаар үйлдвэр байгуулахад судалгааны зардал төлөвлөж суулгаж өгөх хэрэгтэй.

### **Б.Түвшинбаяр:**

1. 2013, 2014 оны ногдол ашиг хуулбарлалтын талаар тогтоол танилцуулж Х.Э-ын 100 % саналаар батлав.
2. Ногдол ашиг хувиарлах тухай тогтоол танилцуулж Х.Э-ын 100 % саналаар батлав.
3. ТУЗ-ын 2015 оны нийт цалин хөлс тухай тогтоол танилцуулж Х.Э-ын 100 % саналаар батлав.
4. ТУЗ сонгох тухай тогтоол танилцуулж Х.Э-ын 100 % саналаар батлав.
5. Зарим арга хэмжээ авах тухай тогтоол танилцуулж Х.Э-ын 100 % саналаар батлав.
6. Эрх олгох тухай тогтоол танилцуулж Х.Э-ын 100 % саналаар батлав.

Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа ирж үнэтэй хувь нэмэр, саналаа солилцсон та бүхэнд баярлалаа.

Хурал 18 цаг 30 минутад дуусав.